



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 238

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Монгол-Ус” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2017, 2018, 2019 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар тус үйлдвэрийн газар нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасныг зөрчин 17.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө зөвшөөрөлгүй бэлтгэсэн, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.4 дэх хэсэгт заасныг тус тус зөрчин хүчин төгөлдөр бус баримтаар 9,9 сая төгрөгийн ажил гүйлгээг хийж санхүүгийн тайланд бүртгэсэн, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 48 дугаар зүйлийн 48.1-д заасныг тус тус зөрчин давхардсан дүнгээр 45,4 сая төгрөгийн худалдан авалт хийсэн зэрэг нийт 57,8 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.“Монгол-Ус” төрийн өмчит үйлдвэрийн газрын санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.“Монгол-Ус” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирал Г.Билэгсайханд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Санхүүгийн сахилга батыг хэвшиүүлэн дотоод хяналтыг сайжруулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх;

2.2. Засгийн газрын 2020 оны 121 дүгээр тогтоолоор “Усны газар” байгуулагдаж, Засгийн газрын 2013 оны 390 дүгээр тогтоолыг хүчингүйд тооцох шийдвэр гарсантай холбогдуулан, хууль тогтоомжийн хүрээнд үйлдвэрийн газрын үйл ажиллагаа, чиг үүргийг өргөтгөх, нэмэлт орлого олох боломжийг одоогийн хүчин чадал, боловсон хүчний туршлага, ур чадвар, усны нөөцийн менежмент хийх хэрэгцээ, шаардлага зэрэг суурилан судалж, санал боловсруулж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;

2.3. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй эд хөрөнгө худалдан авахыг таслан зогсоох;

2.4. Жижиг мөнгөн сангийн хэмжээг нарийвчлан тогтоох, бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний төлбөрөөс бусад тохиолдолд харилцахаар гүйлгээ хийж, бэлэн мөнгөний гүйлгээг багасгах;

2.5. Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ыг мөрдөх, хүчин төгөлдөр бус болон бүрдэлгүй анхан шатны баримтаар ажил гүйлгээ хийхийг таслан зогсоох;

2.6. Санхүүгийн тайланд бүртгэлтэй, 1 (нэг) жилээс дээш хугацаатай авлагыг барагдуулах;

000382

2.7. Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилга байгууламжийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу залруулж бүртгэх;

2.8. Худалдан авах ажиллагаанд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах;

2.9. Үйлдвэрийн газрын орлого, ашигт ажиллагааг дэмжих ач холбогдолгүй, төрийн байгууллагын хамтран зохион байгуулсан ойн арга хэмжээний хандивын орлого, зарлагын гүйлгээг байгууллагын дансаар хийхийг таслан зогсоох, түүнтэй холбогдуулан төлөвлөөгүй өглөг үүсгэх нөхцөл бүрдүүлэхгүй, дээд газрын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй байх;

2.10. Аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг зохион байгуулж, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллах;

2.11. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангах, биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс /Ц.Баяр-Эрдэнэ/-т дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

3.1. “Монгол-Ус” төрийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагаа нь зогсож, 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө тасалдаж болзошгүй байгаа тул Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтарч тус үйлдвэрийн газрыг цаашид хэрхэн зохион байгуулах санал дүгнэлт боловсруулж, шийдвэрлэх арга хэмжээ авах;

3.2. Байгаль орчин аялал жуулчлалын яамтай хамтран Засгийн газрын 2013 оны 391 дүгээр тогтоолын хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийж, санал боловсруулж шийдвэрлүүлэх;

3.3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу “Монгол-Ус” төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалт, дүрмийг шинэчлэн баталж мөрдүүлэх.

4. “Монгол-Ус” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, төслийн хүрээнд бий болсон үл хөдлөх хөрөнгөд бүртгэлээр хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс /Д.Нарангэрэл/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА


3.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц. ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 238 дугаар сарын 23-иүүдээр
тогтоолын хавсралт



“Монгол-Ус” төрийн өмчит үйлдвэрийн газарт
хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг
арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Хамрах хугацаа	Мөнгөн дүн /төгрөгөөр/	Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Шатахуун худалдан авалтын нийт төсөвт өртөгийг үндэслэн харьцуулалт хийгээгүй.	2018-2019	30,800,000.00	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг мөрдөж ажиллах.
2	Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар зарлагын гүйлгээ хийж бүртгэсэн	2017-2019	9,922,026.00	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалт болон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллах.
3	Эрх бүхий байгууллагаас баталсан хөрөнгө оруулалтын болон худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй үндсэн хөрөнгө худалдан авсан.	2017-2019	17,061,250.9	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.8 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж, авах, шилжүүлэх журам”-ын 3.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай 48 дугаар зүйлийн 48.1, Сангийн сайдын 2017 оны 363 тоот тушаалаар батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмыг мөрдөж ажиллах.
	НИЙТ ДҮН:		57,783,276.91	